

## Танилцуулга

(Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ) 2017 оны 8 дугаар сарын байдлаар)

Тус газарт 2017 оны 8 дугаар сард 509 ХАСУМ хүлээн авч, өмнөх сарын 68 үлдэгдэгдэлтэй нийт 577 ХАСУМ шийдвэрлэсэн байна.

Ирүүлсэн мэдүүлгийн тоог байгууллагаар нь авч үзвэл Цагдаагийн ерөнхий газар 68, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ 65, Хил хамгаалах ерөнхий газар 31, Онцгой байдлыг ерөнхий газар 30, Гадаад харилцааны яам 23, Зэвсэгт хүчний жанжин штаб 23, Төрийн банк 20, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар 18 ХАСУМ тус тус ирүүлсэн нь хамгийн олон болж байна.

**Хүснэгт 1. Ирүүлсэн мэдүүлгийн тоо, 2017 оны 8 дугаар сарын байдлаар, байгууллагаар**

Ирүүлсэн байгууллагаар	Мэдүүлгийн тоо
Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ-т	82
Цагдаагийн ерөнхий газар	68
Хил хамгаалах ерөнхий газар	31
Онцгой байдлын ерөнхий газар	30
Гадаад харилцааны яам	23
Зэвсэгт хүчний жанжин штаб	23
Төрийн банк	20
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	18
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	15
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	12
Тагнуулын ерөнхий газар	12
Гаалийн ерөнхий газар	11
Монгол Улсын Боловсролын Их сургууль	10
Монгол Улсын Ерөнхий прокурорын газар	10
Нийслэлийн МХГ	10
Зам, тээврийн хөгжлийн яам	8
Хөгжлийн банк	8
Соёл урлагийн их сургууль	6
Татварын ерөнхий газар	6
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	6
Гадаадын иргэн, харьяатын газар	5
Замын-Үүд чөлөөт бүсийн захирагч	5
Шинжлэх ухаан технологийн их сургууль	5
Барилга, хот байгуулалтын яам	4
Батлан хамгаалахын яам	4
Засгийн газрын хэрэг эрхлэх газар	4
Баянхонгор аймгийн ЗД	4
Шивээ-Овоо ХК	4
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	4
Бусад (тухайн байгууллагаас 3-аас доош мэдүүлэг)	129
Дүн	577

ХАСУМ-ийг томилогдох аймаг, нийслэлээр нь авч үзвэл Улаанбаатар хотод 484 ХАСУМ, Дорнод, Сэлнгэ тус бүр 9, Баянхонгор, Хэнтий, Хөвсгөл тус бүр 8, Орхон 7 ХАСУМ ирүүлсэн хамгийн олон болж байгаа бол Баян-Өлгий, Архангай, Булган аймгаас харьцангуй цөөн тооны ХАСУМ ирүүлсэн байна.

2017 оны 8 дугаар сарын байдлаар төрийн тусгай албан тушаалд 225, төрийн захиргааны албан тушаалд 148, төрийн үйлчилгээ 90, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 52, төрийн улс төрийн албан тушаалд 45 ХАСУМ ирүүлсэн нь хамгийн өндөр дүн болж байна. Эдгээрийн 270 нь удирдах, 7 нь бусад албан тушаал байгаа бол 300 нь гүйцэтгэх албан тушаал байна.

**Хүснэгт 2. Ирүүлсэн мэдүүгийн тоо, 2017 оны 8 дугаар сарын байдлаар, томилогдох албан тушаалын ангилалаар**

Томилогдох албан тушаалын ангилал	Тоо
Төрийн тусгай	225
Төрийн захиргааны	148
Төрийн үйлчилгээ	90
Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	52
Төрийн улс төрийн	45
Бусад	10
Ажлын алба	4
Төрийн бус байгууллага	2
Төрийн өндөр	1
Дүн	577

2017 оны 8 дугаар сард ХАСУМ-ыг дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Ашиг сонирхлын зөрчил үүсээгүй 86.7 хувь, ажлын байрны тодорхойлолт болон хуульд заасан шаардлага хангаагүй 6.4 хувь, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсныг анхааруулсан 2 хувь, томилсон тушаал, захирамжийг хүчингүй болгуулахаар буцаасан 2 хувь, томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлээгүй 1.1 хувь, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон 0.7 хувь, холбогдох материал дутуу 0.7 хувь, хуулийн үйлчлэлд хамаарахгүй болон ашиг сонирхлын илт зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдсон 0.2 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 3. 2017 8 дугаар сард ирүүлсэн мэдүүгийн шийдвэрлэлт, хувиар**

Шийдвэрлэлт	Хувь
Ашиг сонирхлын зөрчил үүсээгүй	86.7
Ажлын байрны тодорхойлолт болон хуульд заасан шаардлага хангаагүй	6.4
Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсныг анхааруулсан	2.0
Томилсон тушаал, захирамжийг хүчингүй болгуулахаар буцаасан	2.0
Томилох эрх бүхий байгаа а/т-с ирүүлээгүй	1.1
Ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон	.7
Холбогдох материал дутуу	.7
Ашиг сонирхлын илт зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдсон	.2
Хуулийн үйлчлэлд хамаарахгүй	.2
Дүн	100.0